

IV. Монголчуудын уламжлалт эрдэм ухаан

МОНГОЛЧУУДЫН “ТЭНГЭР УНШИХ” ЭРДЭМ УХААНЫ УЧИР ХОЛБОГДОЛ

Л.Чулуунбаатар

Монгол Улсын Их Сургууль, Ни йгмийн Шинжлэх Ухааны Их Сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга:Энэ өгүүлэлд монголчууд цаг улирлыг тэнгэрийн эрхэс, байгалийн элдэв үзэгдлээр шинжиж ахуй амьдралдаа тэдгээрийг онцгойлон анхаарч зохицож аж төрж ирснийг цөөн баримтанд тулгуурлан авч үзнэ. “Тэнгэр унших” эрдэм ухаан бол өнө эртнээс уг үндэстэй, асар их сургамжтай билээ. Өнөөгийн нөхцөлд ус цаг уурыг шинжих нь зөвхөн малчдад төдийгүй, хүн болгонд чухал ач холбогдолтой. Хүн байгаль хүйн холбоотой учраас байгаль ус цаг уурын өөрчлөлтөнд ахуй амьдралаа зохицуулахаас өөр арга зам байхгүй.

Түлхүүр үг: Үүл, салхи, хур чийг, ган, зуд.

Хөх мөнх тэнгэр, хөрст алтан дэлхийн савсалганд хүмүүн заяа бүрдсэн хэн боловч хойч үеэ бодож, хорвоогийн жаргал зовлонг эдэлж явна. Өнө эртнээс өдгөө хүртэл алтан наран, алиман саран, од мичдийн тохиох бяцхан чөлөөнд хүн төрөлхтөн оршин буй бөгөөд байгалийн элдэв үзэгдэл, гамшиг хүндрэлийг ч бишгүй амссан билээ. Нэн ялангуяа сүүлийн 20 гаруй жилийн туршид дэлхийн цаг уурын дулаарлын улмаас ган, зуд, үер ус, салхи шуурга ихэд тохиолдож газрын доройтол үлэмж гүнзгийрч, гамшиг сүйтэл асар их болсон юм. Энэ бүхний буруутан нь байгаль өөрөө биш, хүн төрөлхтөн ажээ. Хүмүүс байгальтай харьцахдаа яагаад алдсан бэ? Ер нь түүхийн урт удаан хугацаанд хүн төрөлхтөн үлэмж алдаж байсны шалтгаан юунд оршиж байв гэх мэт олон асуудал зүй ёсоор тулгарч байна. Энэ бүхнийг эргэцүүлэн, өөрийн бодол санаагаа энэ өгүүлэлд товчхон илэрхийлэх зорилт тавьлаа. Уг асуудлыг мөнх тэнгэрийг үзэх үзэл, хандлагатай уялдуулахыг ч би бас чармайсан юм.

Дээр үеэс монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхлэх явцдаа байгаль орчноо танин мэдэх, зүй тогтлыг нь ухамсарлан ойлгохыг хичээж энгийн ухамсрын түвшинд их төлөв ердийн ажиглалт, сорилт хийж иржээ. Юуны өмнө мал амьтан, өвс ургамал, ус унд, хужир шүү, улмаар тэнгэр эрхэс, од мичид, тэдгээрийн хувирал өөрчлөлтийг ч хүмүүс олон жил уйгагүй ажиглан харьцуулж өглөө мандах нарнаас шөнө дөл болтол нэг ёсондоо “тэнгэртэй ярьж” өнгөрөөдөг байжээ. Иймээс монголчуудын дунд “эрт босвол нэгийг үзэх, орой унтвал нэгийг сонсох” гэсэн үг хэллэг бий болсон ажээ. Тэнгэрийг шүтэх, шинжих нь монголчуудад ахуй

амьдралын бодит шаардлагаар зайлшгүй байсан, ардын мэдлэг ухааны нэг том ололт болсон юм. Мөнх хөх тэнгэр ч малчин түмнээс сайн муугаа нуугаагүй, ааш араншингаа ч алдаагүй, болдог юм болдгоороо болж санаа сэтгэл, бэл бэлтгэл, аж ахуй, амьдрал тэмцлийг нь ч сорьж шалгасаар, сургамж туршлага өгсөөр иржээ. Энэ бүхнийг гэрчлэх ардын сайхан үг сургаал ч олон бий. Тухайлбал, “зуд болох зунаасаа”, “бэлтгэл ихтийн бэл их”, “тэнүүн явахад тэмээгээр тусалснаас, тэвдэж явахад тэвнээр тусал”, “тэвний чинээ нүхээр тэмээн чинээ жавар орно” гэх мэт хэлэлцдэг нь чухамдаа монголчуудын хувьд “тэнгэр уншсаны” үр дүн гэлтэй.

Судалгааны бүтээлүүдээс үзэхэд, эрт үеэс монголчууд байгалийн хувирал өөрчлөлтийн үндсийн үндэс болсон цаг уурыг нарийн ажиглаж, “цаг уурын рентээр амьдарч”, ган, зуд болох шинжийг нягтлан, хур ус, салхи шуурга дэгдэх, эсэхийг тэнгэр эрхсийг харж мэдэж чаддаг өв уламжлалыг бий болгожээ. Энэ өв уламжлалаас зарим жишээг дурдвал:

Халуун намраар хүйтэн бороо, цас шамрага холилдон газар газар адилгүй орох, үүл бүрхэх нь үлэмж, цас дараа дараагаар орж арилах нь удаан, тэнгэрийн хаяа бүрхэх хиртэй мэт цайрах, салхи зүүн ба өмнөөс голдох нь зуд болохын шинж /1; 39/ гэнэ. Халуун намар, өвлийн хэрд салхи баруун ба баруун хойд зүгээс голлох, цасны үзүүр эрт үзэгдэвч орох нь хойрго, оровч бага, арилах нь түргэн, бүрхэх нь удаан харагдах тэнгэрийн хаяа өнгөлөг байваас өн болохын шинж гэдэг. Эдгээр шинжийг харьцуулахад, зуд болох жилийн намраас тэнгэрийн хаяа их бүрхэх, булингартай бол өн болоход тунгалаг, цэлмэг байдаг нь эдүгээ үед ч ажиглагдаж байна. Тийм учраас “ган зудаас хамгаалахад улирлыг шинжих, хатуу бэрхийг үзэхгүй газрыг зааж ардын малыг идээшлүүлэн бэлчээх тохь бүхий газар нүүдэллэх” /2; 55/ явдлыг чухалчилж байв. Бас “тохирох газруудад худаг шуудуу малтах татах” /3; 5/ аргыг дээр үеэс ашиглаж иржээ. Өглөөнөөс эхлэн өдөржин малчид тэнгэр ширтэж үүлс нүүж салхи ширүүсэх төлөв бүхий бол малын хариулга маллагаагаа өөрчилж хур бороо, цас шамрага орохоор болбол гэр хотноосоо холгүй нөөц бэлчээрийг ашигладаг байв. Тэнгэр хангай маань өршөөнө биз гэж бодовч тэвдэж амжуулж ус түлш, бусад бэлтгэлийг сайтар хангадаг нь малч түмний ёс байлаа.

Манай орны тал хээр, говийн бүсийн зарим ахмад хашир малчид намар оройхон нутгийн өндөр ууланд гарч шөнөжин үүлний нүүдэл, салхины чиг, тэнгэрийн хаяаг ажиглан өвөл, хаврын байдлыг шинждэг байв. Энэ бол

монголчуудын "тэнгэр унших" эрдэм ухааны нэг эрхэм илрэл, ахуй амьдрал, ажил үйлсэд нэн тустай арга юм. Гэвч энэ аргыг хэрэглэхэд өнөө үед бодууштай зүйл их байна. Учир нь дэлхийн агаар мандлын озоны давхрага цоорч нарны хэт ягаан туяаг шүүх шүүлт муудсанаас гадны агаар орчны бохирдолттой холбоотойгоор үүлний нүүдэл, чиглэл, хур тундасны байдалд ихээхэн өөрчлөлт оржээ. Энэ байдлыг харгалзан, дан ганц уламжлалыг шүтэх биш, ус цаг уур орчны хүрээлэнгийн урьдчилан сэргийлэх мэдээ сэлтийг онцгой анхаарах шаардлагатай болж байна.

Зарим хүмүүс тэнгэрийн ааш араншинг хэрхэн мэдэх билээ гэж алмайрах, үл тоох хандлагатай байдаг нь үндсэндээ зохисгүй, өмнөх уламжлал, өвгөдийнхөө сургаалаас сурч мэдэх, авч хэрэглэх зүйл асар их гэдгийг зориуд онцлон тэмдэглэе. Уламжлал шинэчлэж байхгүй бол шинэ үр дүнд үл хүрэх хор уршигтай учраас зөв зүйтэй хослуулах зайлшгүй шаардлагатай юм. Эл учраас өмнөх үеийн өв уламжлалаас товч эргэцүүлэх нь танин мэдэхүйн төдийгүй, практик ач холбогдолтой билээ.

Өглөө тэнгэр цэлмэг, нар тосон цагаан цацраг нь хурц байвал өдөртөө тэнгэр тогтуун байдаг бол тэнгэрт бөөн долгиолог, сэмжин үүлс ажиглагдвал цаг агаар муудах шинж болдог. Өглөөний нар гурав байвал ойрын үед цаг агаар муудах, оройн нар гурав шингэвэл маргааш цаг агаар сайхан байна гэж үздэг байв. Бас үүл хөндлөн байрлалтай байваас хур бороогүй, хэрэв үүлийн толгой босоо бол хур ус орно гэдэг. Хуучны үгэнд "орох тэнгэрийн орой цоорхой" гэх, бороо цас орж буй үед хаяа ажиглагдвал тэнгэр арилна хэмээн шинждэг. Мөн салхи өмнөөс олон хоног салхилбал тэнгэр урьж байна, үүлээ хойш нь их хийсэн болохоор заавал хур бороо орно, олон хоногийн зүсэрсэн бороо ч орж магадгүй гэдэг. Малчид "хаврын тэнгэр хартай" гэдгийн учир нь хавсрага хэмээх хүчтэй салхинаас гадна гэнэт тэнгэр бүрхэж цасан шамрага нүүр нүдгүй орж мал уруудаж, үс ноолуурыг авсан мал осгож үхдэгтэй шууд холбоотой. Тиймээс хавар малаа гэр хотныхоо ойр, салхины дээд талд хариул, гэнэт тэнгэр муудаж мал уруудвал хотондоо орж ирнэ. Хавар гол нуураас хөндий зайтай нутагла гэдэг байжээ. Түүнчлэн намрын улиралд цас бороо холилдон их хэмжээгээр орвол аргал түлш өтөг бууц, бэлчээр нутаг хөлдөж "мөсөн зуд" болохын шинж ажээ. Зуны улиралд өдөртөө их халуун, шөнөдөө сэрүүн, жиндүү хэртэй бол гангийн дохио гэх зэргээр

малчин ардууд цаг шинжиж иржээ. Энэ бүхэн нь монгол ардын уламжлалт мэдлэг ухааны арвин өв санг бүрдүүлсэн, асар их сургамжтай үнэт сургаал болсон билээ.

Байгалийн нөхцөл өнөө үед ихээхэн ядуурч байгаа учраас “тэнгэр унших” эрдмээс суралцах ажил үйлсдээ ашиглах явдал манай иргэдэд их ач холбогдолтой. Монголчууд нар, сар солонгорох, хүрээлэх, салхи хавсрага тавих зэрэг тэнгэрийн ааш араншинг андахгүй тул ахуй амьдралаа түүнд тохируулан аж төрж иржээ. Энэ мэдлэг ухаан нь “нарыг шинжих судар”-т зааснаар, “наран харанхуйлан таван өнгө голлон хүрээлэн хар уур гарваас их ган болно” гэсэнтэй үндсэндээ дүйцсэж байна. Ган гамшиг дагуулдаг болохоор зуд болж мал сүрэг их хорогдож ард олны аж байдал доройтдог үр дагавартай юм. “Ганг агаар мандлын, хөрсний, агаар хөрсний гэж гурван төрөл хуваахын дээр хамрах нутаг дэвсгэрийн хэмжээгээр нь орон нутгийн (10хувиас бага), ихээхэн (21-30 хувь), онцгой их (31-50 хувь) гамшгийн хэмжээнд хүрсэн (50 хувиас их) гэж ангилдаг байсан. /4; 79/

Өнөө үед агаар хөрсний ган орон нутагт зонхилж дулаарлын улмаас ус чийг ховордож хэт хуурайших, гол нуур ширгэж гадаргын усны нөөц багасахын зэрэгцээ хүчтэй салхи дэгдэх, гэнэт их ус бууж үер болох, хөрсний үржил шим буурч өвс ургамлын гарц, шимт чанар муудах, зэрлэг, хог ургамал голлох болж байна.

“Тэнгэр унших” эрдмийн ачаар байгалийн элдэв үзэгдлийг зогсоож болохгүй боловч түүнээс учрах үлэмжийн сүйтгэл, хор хөнөөлийг багасаж чадах юм. Бас урьдчилан сэргийлэх боломжийн бүх арга хэмжээг хэрэгжүүлэх үндэстэй билээ.

Энэ бүхнээс үндэслэн, би дараах зарим санал дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

- Дээд тэнгэрээс заяат төрсөн /5; 25/ монголчууд “түүхэнд оюун санааг нэмэрлэж, дэргэдэх хонь малаа илүү чухалчилжээ” /В.Гегель/. “Хүн төрөлхтний эртний шүтлэгийг ашиглан германы философич, залуу гегельч асан Макс Штирнер (Каспар Шмидт 1806-1856) « . . . Монгол овогтонд шүтлэг нь ахуй сэтгэлийг нь эзэмшсэн төрөлхийн чанар бөгөөд монгол арьстны шаргуу тэмцэл нь ТЭНГЭР БУРХНЫГ бий болгосон явдал мөн » хэмээн маш бодитой, гайхамшигтай дүгнэлтийг хийсэн байдаг. /6; 47/
- Монголчуудын бий болгосон тэнгэр бурхныг мөнх тэнгэрийн үзэл /тэнгэризм/ гэж нэрлэдэг агаад эцэг тэнгэр, эх дэлхийн хишиг буянд шүтэж, идээ ундааныхаа дээжийг өргөж, санаа зөв бол заяа зөв хэмээн итгэж, эрч хүч нэмж, ертөнц дахинаа манай өвгө дээдэс нэр алдраа цуурайтуулж ирсэн билээ.

- Оросын нэрт эрдэмтэн Л.Н.Гумилев, “байгаль орчноо мэдэхгүйгээр түүхээ зөв ойлгохгүй, түүхээ бүрэн мэдэхгүйгээр байгаль орчиндоо зөв хандаж чадахгүй” гэжээ. Энэ учраас монголчуудын “тэнгэр унших” эрдэм ухаан бол тэнгэрийг шүтэх үзэл дээр тулгуурласан цаг уурын эрс өөрчлөлтийн нөхцөлд байгаль хамгаалах, уг өөрчлөлтөнд “Дасан зохицох” бодлогыг дэлхий дахинд, түүний дотор монгол улсад баримтлах нь зүйтэй гэж үзэж байна. НҮБ-ын байгаль орчны хөтөлбөрийн хүрээнд дэлхийн 25 оронд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын судалгааны төсөл хэрэгжиж байгаа билээ. Судлахаас гадна бодит ажил хэрэг болгох явдал өнөөгийн тулгамдсан зорилгын нэг мөн.
- Өнөөгийн нөхцөлд “тэнгэр унших” ардын уламжлалт арга ухааныг ашиглахын зэрэгцээ ус цаг уур, байгаль орчны шинжлэх ухааны үндэстэй урьдчилан сэргийлэх мэдээ, анхааруулгыг тогтмол сонсож ажил үйлсдээ хэрэглэх нь малчид, олон түмэнд чухал ач холбогдолтой билээ. Байгалийн гамшгаас учирч буй хохирлын нэлээд нь хүмүүсийн хайхрамжгүй, хэнэггүй байдалтай холбоотой ажээ. Мөн “тэнгэр унших” уламжлалт эрдэм ухааныг төгс эзэмшсэн ахмадууд улам цөөрч, залуу үеийнхэн түүнийг нь тоож үзээгүйгээс өвлүүлэн үлдээх ажил ч орхигдсон байна.
- Монгол ардын уламжлалт мэдлэг ухаан нь цаг үе, нөхцөл байдал, хэдий өөрчлөгдсөн ч манай орны байгаль, газар орон, ус, цаг уурын өвөрмөц онцлогтой гойд уялдаа холбоо бүхий учраас үеэ өнгөрөөж үнэ цэнээ алдах ёсгүй. Харин ч ойрын хэдэн жилийн ажиглалтын үндсэн дээр одоогийн төлөв байдлыг үнэн зөв тодорхойлж, урьд өмнөх уламжлалт мэдлэг ухааны ололтоос шинэчлэлийн үзэл санаа, шинэ арга технологитой хослуулан хэрэглэвэл илүү үр дүнд хүрэх магадлалтай билээ. Энэ нь зөвхөн малчдад төдийгүй, хэн хүнд хэрэгтэй гэж үзэж байна.
- Хүний буруутай үйл ажиллагааны улмаас агаар орчин, хөрс, ус бохирдож, шимт чанар, цэвэр цэнгэг байдал алдагдаж, эргээд экологийн сүйрэлд хүргэж байгаа юм. Энэ бол хүн төрөлхтний гаргасан хамгийн том алдааны нэг даруй мөн. Одоо энэ алдаанаасаа сургамж авч, засаж залруулахгүй бол хүн төрөлхтөн орших, эсэх асуудалтай тулгарна. Энэ асуудалд зөв зүйтэй хариу өгөхөд монголчуудын уламжлалт тэнгэрийн үзэл, түүн дээр

үндэслэсэн “тэнгэр унших” эрдэм ухаан тодорхой хэмжээгээр ач тустай болно.

Мөнх хөх тэнгэрээ дээдлэж, ардын арга ухааны өв уламжлалаас цуцалтгүй суралцаж явбал монголчуудад хөгжил дэвшлийн сайхан ирээдүй учран золгож амны хишигтэй, амжилт бүтээл арвин байх нь дамжиггүй.

Эх болсон газар дэлхийгээ хайрлаж

Эцэг болсон мөнх тэнгэрээ дээдлэе.

Abstract: This is one of the achievements of traditional lore. As the study of weather will be existing, it is necessary to enrich it by advanced viewpoint. The further research of this issue has a significant benefit.

Ном зүй

1. Т.Т.А, Ф.15,т.2, х/н.347
2. Т.Т.А, Ф.15,т.2, х/н.3. Мал тариалангийн яамны дүрэм, аж ахуй, түүхэн лавлагаанд холбогдох тэмдэглэл.1930
3. Ардын ажил ахуйг сайжруулах хоршооны дүрэм.УБ.1929
4. Б.Цацрал, Л.Нацагдорж. Монгол орны нутаг дэвсгэр дээрх агаар мандлын ган ба дэлхийн далай, агаар мандлын том хэмжээст харилцан үйлчлэлийн уялдааны асуудалд. УБ.2003
5. Монголын нууц товчоо.УБ.1990
6. П.Давааням. Суврагын онол.УБ.1998
7. Монгол орны байгаль орчин.УБ.1998
8. Л.Нацагдорж, П.Батима. Уур амьсгалын өөрчлөлт.УБ.2002
9. Д.Шаарийбуу. Малчдын мэдүүштэй тавин зүйл. УБ.1967
10. Л.Балдандаш. Жилийн өнгө малын цариг.УБ.1959
11. Монголчуудын “тэнгэр унших” эрдэм ухааны уламжлал. УБ.1999
12. Монгол улсын түүх (Түүх, онол-арга зүйн асуудлууд) УБ.1999
13. Д.Жанцан, Д.Гарамжав, А.Маргай. Байгалийн гамшиг хүн төрөлхтөн. УБ.1989
14. Ж.Самбуу. Мал аж ахуйдаа яаж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал.УБ.1987
15. Н.Хавх. Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан. УБ.2000
16. Ким Жон Рэ. Их шуурганаар сийлэгдсэн түүх. Сөүл.2001